



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ
ТӨМӨР ЗАМ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 17 өдөр

Дугаар Б/40

Улаанбаатар хот

Буцалтгүй тусламж олгох тухай

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.38 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.3.3 дахь хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246, А/248 дугаар тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Буцалтгүй тусламж олгох” журам /код 932/-ийн 932.2.1 “а” дахь заалт, “Байгууллагын даргын тушаал гаргах” журам /код 136/-ийн 136.5.2-ын “г” дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус цагдаагийн газрын ахмад настан Дамдинжавын Баярсайхан нь өвчний улмаас нас барсан тул 100.000 /нэг зуун мянган/ төгрөгний буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжаар олгох 100.000 /нэг зуун мянган/ төгрөгийг зохих зардлаас зарцуулахыг ахлах нягтлан бодогч, /цагдаагийн ахмад Д.Отгондалай/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

ХУУЛБАР ҮНЭН: Захиргааны удирдлагын тасгийн дарга,
цагдаагийн дэд хурандаа

Д.БАТСАЙХАН

С.БАЯРБАТ

